

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 14

Номгон

Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хүний нөөцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Нэг. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах 2021 оны ололт, амжилтыг нэгтгэн дүгнэж, зөрчил дутагдлыг хэлэлцэн 2022 онд дэвшүүлэн тавьж буй зорилго, зорилтыг харилцан санал солилцон сайжруулахаар аймгийн “Хөгжлийн зөвлөгөөн”, “Төрийн байгууллагуудын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”, “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагын зөвлөгөөн”, “Барилгын салбарын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”, “Хөдөө аж, ахуйн сургалт зөвлөгөөн”, “Боловсролын салбарын сургалт, зөвлөгөөн”, “Эрүүл мэндийн салбарын сургалт зөвлөгөөн” “Ойн анхдугаар чуулган”-ыг аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа бодлогын хэлтсүүд хариуцан зохион байгууллаа.



Зураг дээр: Аймгийн “Хөгжлийн зөвлөгөөн”-2022 он




Зураг дээр: “Төрийн байгууллагуудын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн” - 2022 он



Зураг дээр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Баянхонгор аймгийн Ойн салбарын анхдугаар чуулган”-2022 он

Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн чухал бөгөөд өргөн хүрээтэй зохион байгуулагдсан ажил бол Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг ахлуулсан ажлын баг Баянхонгор аймагт ажиллаж, төрийн албан хаагчидтай уулзаж, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоо, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, орон нутаг дахь төрийн албаны хүний нөөцийн хүрэлцээ, хангамж, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт, төрийн бүтээмж зэрэг төрийн албаны шинэтгэлийн тухайлсан сэдвүүдээр мэдээлэл өгч, зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийг өрнүүллээ.



Зураг дээр: “Төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага” сэдэвт сургалт

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачлагыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор “ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА” аяныг 2021, 2022 онд уламжлал болгон зохион байгуулсан.

Аяны хүрээнд:

1. "Өөрөө манлайлж, өөрөө үлгэрлье" төрийн албан хаагчдын шинэ санал, санаачлагыг дэмжих;
2. "Мэргэшсэн төрийн алба- Мэдлэг, чадвар, сэтгэлээр бэхжинэ" сэдэвт төрийн албан хаагчдын 3 үеийн уулзалт зохион байгуулах;
3. "Чадварт тулгуурлаж, чанар хүртээмжтэй үйлчилье" үзүүлэх сургууль зохион

байгуулах зорилтуудыг дэвшүүлэн аймгийн хэмжээнд дараах ажлыг зохион байгуулсан.

Аяныг зохион байгуулснаар аймгийн хэмжээнд төрийн албаны нэр хүнд дээшилж, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн, төрийн албаны салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбох өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурсан байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, E-Mongolia академи, "Эмпасофт" ХХК, ICT Group хамтран "Дижитал Баянхонгор" арга хэмжээг 3 өдөр нийт 187 байгууллагын 598 албан хаагчийг хамруулж, төрийн байгууллагын удирдлага, IT инженер, мэдээллийн технологийн ажилтнууд "Цахим үндэстэн –Дижитал аймаг", "Тогтвортой хөгжил- технологийн шийдэл, ач холбогдол", "Дижитал орчинд ажиллах, чадварлаг хүмүүсийг бэлтгэх сургах боломжууд" сэдвээр сургалтуудыг зохион байгуулав.



Зураг дээр: "Дижитал Баянхонгор" арга хэмжээ

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалтыг ХНХЯ,-аас Баянхонгор аймагт зохион байгууллаа. Сургалтад орон нутгийн төрийн болон ТББ, ажил олгогчдын төлөөлөл 30 гаруй холбогдох удирдлага, албан хаагчид оролцов.



Зураг дээр: "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалт

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сумдын Засаг даргын Тамгын газрын бодлогын баримт бичиг,

хууль тогтоомжийн тайлагналтыг чанаржуулах, албан хаагчдыг чадваржуулах сургалтыг 2 өдөр зохион байгуулав. Сургалт бодлогын хэлтсүүдийн харьяа агентлагуудын дарга эрхлэгч, тайлан мэдээ хариуцдаг хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтнүүдийг танхимаар болон цахимаар хамруулж нийт 100 гаруй албан хаагчийг хамруулав.



Зураг дээр: Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн тайлагналтыг чанаржуулах, албан хаагчдыг чадваржуулах сургалт

Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад шаардлага хангасан 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 8, давтан сургалтад 6, чиглүүлэх богино хугацааны сургалтад 12 албан хаагчийг хамруулсан байна. Мөн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, мэргэжлийн чадварыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн Богино хугацааны зорилтот сургалтуудад 16 албан хаагчийг хамруулсан.



Зураг дээр: Чуулганд Төрийн архив болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны ажилтнуудыг төлөөлж Төрийн архивын тасгийн дарга, В.Эрдэнэчимэг Орон нутгийн Төрийн архив, ба байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн өнөөгийн хөгжил сэдвээр илтгэл тавилаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэмжлэгтэйгээр “Шинэ сэргэлт-Цахим архив” сэдэвт Архив, албан хэрэг хөтлөлтийн

ажилтнуудын Анхдугаар чуулганд Баянхонгор аймгаас нийт архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудаас Архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэг, фондч Б.Оюунтуяа, ахлах архивч Т.Ууганцэцэг, Аймгийн ЗДТГ-ын архив бичиг хэргийн эрхлэгч Н.Наранцэцэг, Баянхонгор сумын ЗДТГ Г.Должинсүрэн, Биеийн тамир спортын газрын бичиг хэрэг н.Гансүх, Номгон сургуулийн бичиг хэрэг Б.Далайжаргал нарын шилдэг ажилтнууд төлөөлөн оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын А/336 дугаар захирамжаар нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг сургахад 10 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөр Удирдлагын чиглэлээр 2 мэргэжилтэн, Глобал Удирдагч их сургуульд 10 сувилагч суралцаж байна. Эрүүл мэндийн ажилчдын нийт 80 хувь ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.

Нийгмийн ялгаатай салбаруудын топ түвшний удирдлага, CEO, их дээд сургуулийн тэргүүлэх зэрэгтэй эрдэмтэн судлаачид нэг дор цуглаж дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй удирдлага, хүний нөөцийн олон талт асуудлуудын талаар хэлэлцэх, туршлага хуваалцах, харилцан суралцах “Олон улсын хүний нөөцийн форум-2022 Сөүл”-д тус аймгаас 20 сумын Засаг даргын тамгын газрын дарга болон аймгийн Засаг даргын тамгын газраас 4 албан хаагч оролцсон.



Зураг дээр: БНСУ-ын Сөүл хотод 2022.10.28-2022.11.04-ний өдрийн хугацаанд зохион байгуулагдсан олон улсын хүний нөөцийн форум

Бүгд Найрамдах Сингапур улсад зохион байгуулагдсан “Төрийн албаны удирдах албан тушаалтны чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргал хамрагдсан.

Тайлант онд томоохон хэмжээний 32 удаагийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдаж, түүнд 1833 төрийн албан хаагчийг хамруулсан байна.

Хоёр. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна.

Тайлант онд болзол, шаардлагыг хангасан 37 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгов.

Төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байдал:



2022 онд зэрэг дэв олгосон байдал:



Сумдын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр:

“Тэргүүний сум”-аар Т.Эрдэнэбат даргатай Өлзийт сум шалгарч 5,0 сая, дэд байранд Ж.Хатанбаатар даргатай Баян-Овоо сум орж 4,0 сая, “Гутгаар” байранд Д.Лхагвадорж даргатай Бууцагаан сум орж 3,0 сая, Д.Өлзийбаяр даргатай Богд сум, 81,64 хувь буюу 4,08 оноо авсан Г.Энхбаяр даргатай Баянхонгор сум тусгай байрт шалгарч 1,5 сая төгрөгөөр тус тус шагнуулсан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр: “Тэргүүний байгууллага” –аар С.Рэнцэндагва даргатай Татварын хэлтэс шалгаран 4,0 сая, “Дэд” байранд Хурандаа Б.Оюутболд даргатай Цагдаагийн газар шалгарч 3,0 сая, “Гутгаар” байранд Н.Энхжаргал даргатай Эрүүл мэндийн газар орж 2,0 сая, Н.Бямбадорж даргатай Мэргэжлийн хяналтын газар, 95,1 хувь буюу 4,75 оноо авсан Д.Даваажаргал даргатай Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тус тус тусгай байранд шалгарч 1,0 сая төгрөгөөр шагнуулсан.



Зураг дээр: “Тэргүүний сум”-аар Т.Эрдэнэбат даргатай Өлзийт сум, “Тэргүүний байгууллага” –аар С.Рэнцэндагва даргатай Татварын хэлтэс шалгарав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2021 онд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн үнэлгээгээр манлайлж Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Д.Сарангарав даргатай Хууль, эрх зүйн хэлтэс гуравдугаар байранд шалгарсан тул 1.000.000 (нэг сая) төгрөгөөр, Төрийн архивын улсын үзлэгийг 2021 оны IV дүгээр улиралд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт, Төрийн архивын удирдлага зохион байгуулалт, Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, Цахим сан бүрдүүлэлт гэсэн чиглэлээр Архивын ерөнхий газраас зохион байгуулан дүгнэж Баянхонгор аймгийн Төрийн архив тэргүүн байрт шалгарсан тул 2.000.000 (хоёр сая) төгрөгөөр тус тус шагнаж урамшуулав.



Зураг дээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын батламж, өргөмжлөл

Төрийн байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 2 албан хаагчийг “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, аймаг байгуулагдсаны түүхт 80,81 жилийн ойг угтан төрийн одон медалиар 50 гаруй албан хаагчийг, салбарын болон аймгийн шагналаар 80 гаруй албан хаагчийг тус тус шагнаж урамшууллаа.

Байгууллагын 2022 онд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн үнэлгээгээр манлайлан ажилласан Санхүү, төрийн сангийн хэлтэс мөн 19 албан хаагчийг шагнаж урамшуулав.



Зураг дээр: 2022 оны шилдэг албан хаагчид

Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2.071.7 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, 1 сумын Засаг даргын тамгын газрын барилга, 3 байгууллагын компьютер, тоног төхөөрөмж, 20 сумын 40 багт мотоцикл, 3 сумд авто машин, 3 байгууллагад авто машин, Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасагт 160 сая төгрөгийн өртөг бүхий LH8800 загварын амьсгалын аппаратыг шийдвэрлэсэн байна.



Зураг дээр: Авто машин болон тоног, төхөөрөмжийг гардуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар холбогдох байгууллагууд хамтран тус аймагт “Эрүүл Монгол хүн” арга хэмжээг зохион байгуулж 360 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, төрийн албан хаагчийг хамруулсан.



Зураг дээр: Албан хаагчдыг сургалт, үзлэг, оношилгоонд хамруулж байна.


Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан

гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлсэн. 2021-2022 оны хичээлийн жилд агрономич 1, малын их эмч 2, мал зүйч буюу зоотехникчээр 16 оюутан нийт 19 оюутан суралцахаар гэрээ байгуулан сургалтын төлбөрт 27,2 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлэсэн. Дээрх оюутнаас 1 сурагч төгсөж Баянбулаг сумын Хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байна.

Тайлант онд төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан нөхөх төлбөр 102.572.760 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан тусламжид 195.624.086 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгаанд 1.703.759.690 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАГНАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Д.Отгонжаргал* Д.ОТГОНЖАРГАЛ